



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 306

Улаанбаатар хот

Хаалттай өрийн хэрэгсэл бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Лэндмн ББСБ” ХК-ийн хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй 1,000,000 /нэг сая/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 7,400 /долоон мянга дөрвөн зуу/ ширхэг өрийн хэрэгслийг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/-т зөвшөөрсүгэй.

2. Хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийг бүртгэсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Лэндмн ББСБ” ХК /О.Болдбаатар/-д үүрэг болгосугай.


1/ Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, харилцагч, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хүндэтгэн ажиллах;

2/ Хорооны 2019 оны 210 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх;

3/ Хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийн үндсэн төлбөр, үлдэгдэл, эргэн төлөлтийн талаарх мэдээллийг Хороонд улирал тутам ирүүлэх.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН